13	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	461,142,831.17	619,492,081.68	3,038,845,136.79	4,119,480,049.64
19	1.7 Тайлант үеийн үр дүн	-	-	58,904,893.36	58,904,893.36
20	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	461,142,831.17	619,492,081.68	3,097,750,030.15	4,178,384,943.00

2.5. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,599,992,200.00	1,688,720,385.20
11	3.1.01.1.1 Татварын орлого	425,955,600.00	501,036,409.20
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	398,083,600.00	468,253,279.56
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	398,083,600.00	468,253,279.56
110001	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	298,000,000.00	378,651,086.20
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	3,500,000.00	12,352,908.52
110003	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	49,576,200.00	31,931,805.61
110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	1,109,200.00	1,204,000.00
110008	3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	45,898,200.00	44,113,479.23
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	22,708,200.00	27,011,704.64
113001	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	5,155,700.00	2,999,924.64
113002	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	750,000.00	1,080,000.00
113004	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	16,802,500.00	22,931,780.00
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	5,163,800.00	5,771,425.00
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,865,800.00	3,354,920.00

118001	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	1,365,800.00	529,920.00
118006	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,000,000.00	239,000.00
118009	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	500,000.00	2,586,000.00
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	2,298,000.00	2,366,385.00
118101	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	2,298,000.00	2,366,385.00
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	-	50,120.00
118203	3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	50,120.00
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	1,174,036,600.00	1,187,683,976.00
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	41,500,000.00	58,233,613.00
120003	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	20,000,000.00	6,398,000.00
120004	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	21,500,000.00	45,779,296.00
120009	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	-	6,056,317.00
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	931,701,200.00	931,701,200.00
122003	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	931,701,200.00	931,701,200.00
122005	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	-	
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	200,835,400.00	197,749,163.00
123002	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	200,835,400.00	197,749,163.00
II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,818,731,400.00	1,606,211,658.51
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,493,695,500.00	1,447,594,658.51
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,485,945,500.00	1,441,521,658.51
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	845,149,300.00	829,635,523.76
210101	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	782,422,300.00	534,436,214.75
210102	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	-	293,155,135.01
210104	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	20,987,900.00	2,044,174.00
210105	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	41,739,100.00	-
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,278,400.00	102,278,398.80
210201	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	70,664,700.00	70,664,700.00
210202	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	7,903,300.00	7,903,300.00
210203	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	3,951,800.00	3,951,799.80

210204	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	3,951,800.00	3,951,799.80
210205	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	15,806,800.00	15,806,799.20
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	405,454,200.00	400,846,133.95
210301	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	55,150,900.00	44,951,574.75
210302	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	349,122,500.00	355,054,904.20
210303	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	1,180,800.00	839,655.00
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	40,409,900.00	32,431,540.00
210401	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	8,914,400.00	7,575,000.00
210402	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	18,669,100.00	13,815,540.00
210403	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,878,500.00	6,200,500.00
210405	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	225,000.00	-
210406	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,722,900.00	4,840,500.00
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	1,949,400.00	1,949,400.00
210503	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,949,400.00	1,949,400.00
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	18,340,500.00	17,580,100.00
210602	3.1.01.2.1.1.6.02 Тавилга	2,500,000.00	2,500,000.00
210604	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	15,840,500.00	15,080,100.00
2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	18,524,400.00	17,812,800.00
210702	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	18,524,400.00	17,812,800.00
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,971,900.00	7,542,252.00
210801	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,078,400.00	68,200.00
210802	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	688,000.00	400,000.00
210803	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	267,000.00	241,900.00
210804	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	514,300.00	389,952.00
210805	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	143,000.00
210806	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,550,000.00	5,887,000.00
210807	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	698,200.00	412,200.00
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	42,867,500.00	31,445,510.00

210901	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	36,778,900.00	27,500,910.00
210902	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,088,600.00	3,944,600.00
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,750,000.00	6,073,000.00
2131	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213103	3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт	-	-
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	7,750,000.00	6,073,000.00
213209	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,750,000.00	6,073,000.00
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	217,637,900.00	158,617,000.00
223001	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	217,637,900.00	158,617,000.00
23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	107,398,000.00	-
230001	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	107,398,000.00	-
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	218,739,200.00	82,508,726.69
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(218,739,200.00)	(225,391,426.69)
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(218,739,200.00)	(225,391,426.69)
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	241,467,241.83
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	323,975,968.52
6	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	62.00	62.00
61	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00
610001	6.1.01 Төсвийн байгууллага	2.00	2.00
62	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	30.00	30.00
620001	6.2.01 Удирдах ажилтан	8.00	8.00
620002	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00
620003	6.2.03 Үйлчлэх ажилтан	3.00	3.00
620004	6.2.04 Гэрээт ажилтан	7.00	7.00
65	6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	30.00	30.00
650001	6.5.01 Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.00	11.00
650009	6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7.00	7.00
650010	6.5.10 Гэрээт ажилтан	5.00	5.00
650011	6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ)	7.00	7.00

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	33,901,967.00
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	33,901,967.00
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	33,901,967.00
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	33,901,967.00
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	33,901,967.00
350011	1.1.1.1.1.1.1.1.1 Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,000,000.00
350013	1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,329,382.00
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,000,000.00
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,572,585.00
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,845,650.00
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	27,845,650.00
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	27,845,650.00
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	1,345,650.00
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	1,345,650.00
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	26,500,000.00
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	24,500,000.00
210902	1.1.1.2.1.1.9.2 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	6,056,317.00
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(6,056,317.00)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(6,056,317.00)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төрийн захиргааны байгууллагын манлайллыг дээшлүүлж, Төрийн албаны шинэчлэлийг гүнзгийрүүлж, хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хөгжлийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ мэдээллээр хангах, иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэлд хамрагдсан байгууллагууд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Бусад

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Төрийн албаны тухай хуульд - 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр, 05 дугаар сарын 04-ний өдөр, 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 11 дүгээр сарын 10-ны өдөр, 12 дугаар сарын 07-ны өдөр, 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр,
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорилт гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нэгтгэл тайланд хамрагдсан байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 4,283.8 сая төгрөг болж 141.3 сая төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	241.5	323.9	82.4
Авлага	193.2	148.4	-44.8
Бараа материал	82.7	190.2	107.5
Үндсэн хөрөнгө	3,625.1	3,621.3	-3.8
Нийт хөрөнгө	4,142.5	4283.8	141.3
Өр төлбөр	23.0	105.4	-82.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,119.5	4,178.4	58.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,142.5	4,283.8	141.3

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 323.9 сая төгрөг болж, өмнөх оноос 82.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	241.5	323.9	82.4
Төрийн сангийн харилцах	241.5	323.9	82.4
Дүн	241.5	323.9	82.4

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 323.9 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд байршиж байна. Үүнд: Орон нутгийн ерөнхий орлого

130.4 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 60.1 сая төгрөг, Хоршоо хөгжүүлэх сан 133.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 148.4 сая төгрөг болж, өмнөх оноос 44.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	7.1	5.7	-1.4
Хувь хүмүүсээс авах авлага	63.2	63.0	-0.2
Зээлийн авлага	114.5	71.3	-43.2
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.7	0.9	0.1
Байгууллагаас авах авлага	7.5	7.5	0.0
Дүн	193.1	148.4	-44.7

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэл буурахад Хоршоо хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага буурсан нь голчлон нөлөөлжээ.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 190.1 сая төгрөг болж, өмнөх оноос 107.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Бичиг хэргийн материал	0.4	0	-0.4
Аж ахуйн материал	30.6	47.2	16.6
Сэлбэг хэрэгсэл	0	0	0
Түлш, шатах тослох материал	0	0	0
Барилгын засварын материал	0	0	0
Хүнсний материал	0	0	0
Бусад хангамжийн материал	47.5	139.0	91.4
Мал амьтад	3.9	3.9	0
Дүн	82.5	190.1	107.6

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдлийн өсөлтөд бусад хангамжийн материал өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 3,621.3 сая төгрөг болж, өмнөх оноос 3.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	2,315.7	2,354.2	38.5
Хуримтлагдсан элэгдэл	-386.8	-430.3	-43.5
Авто тээврийн хэрэгсэл	359.6	326.8	-32.7
Хуримтлагдсан элэгдэл	-101.9	-84.3	17.6

Машин тоног төхөөрөмж (компьютер)	170.3	177.6	7.3
Хуримтлагдсан элэгдэл	-97.4	-81.2	16.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	105.0	102.9	-2.1
Хуримтлагдсан элэгдэл	-58.7	-52.2	6.6
Зам, гүүрийн байгууламж	931.0	931.0	0
Бусад үндсэн хөрөнгө	582.8	582.9	0.1
Хуримтлагдсан элэгдэл	-253.1	-269.8	-16.7
Программ хангамж	1.3	6.3	5.0
Хуримтлагдсан элэгдэл	-0.8	-0.9	-0.1
Бусад биет бус хөрөнгө	58.1	58.1	0
Дүн	3,625.1	3,621.3	-3.8

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,621.3 сая төгрөг болж 3.8 сая төгрөгөөр өсөхөд ЗДТГ-ын хөрөнгө нэмэгдсэн нь голчлон нөлөөлсөн байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 105.4 сая төгрөг болж, өмнөх оноос 82.4 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажилтнуудтай холбоотой өглөг	5.5	11.0	5.5
Байгууллагад төлөх өглөг	13.0	78.1	65.1
Хувь хүмүүст төлөх өглөг	4.5	16.3	11.8
Дүн	23.0	105.4	82.4

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр дансны үлдэгдэл 105.4 сая төгрөг болж 82.4 сая төгрөгөөр өссөн нь байгууллага болон хувь хүмүүст төлөх өглөг өссөнөөс шалтгаалжээ.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 4,178.4 сая төгрөг болж, өмнөх оноос 58.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	461.1	461.1	0.00
Хуримтлагдсан үр дүн	3,038.9	3,097.8	58.9
Өмнөх үеийн үр дүн	2,789.2	3,038.8	249.6
Тайлант үеийн үр дүн	249.6	58.9	-190.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	619.5	619.5	0.00
Дүн	4,119.5	4,178.4	58.9

Эх сурвалж: Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,178.4 сая төгрөг болж 58.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.7 Орлогын данс

Өлгий сумын ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн Орон нутгийн төсвийн тодотгол батлах тухай 5/01 дүгээр тогтоолоор Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 445.9 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 507.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 61.5 сая төгрөгөөр илүү буюу 113.8 хувиар биелүүлсэн байна.

3.5.8 Зардлын данс

Төсвийн шууд захирагчдын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зардлын данстай холбоотой нийт 62.5 сая төгрөгийн 2 алдаа зөрчил илэрсэн.

Аудитын илрүүлэлт:

Өлгий сумын Засаг даргын тамгын газар:

Өлгий сумын Засаг даргын тамгын газар нь санхүүгийн байдлын тайланд тайлант үеийн үр дүнг 239.4 сая төгрөгийн илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх хэсэгт “Үнэн зөв байх”, 14.4 дэх заалт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалт “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.6 дахь заалт “Бүх зардал” гэж заасантай нийцэхгүй, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэсэн.

Аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс Увс аймгийн 100 жилийн ойн хандивын 62.5 сая төгрөгийн хандивыг Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан авсан зөрчилд зөвлөмж өгсөн.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,818.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,818.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Өлгий сумын 2025 оны төсвийг сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 2/12 дугаар тогтоолоор 1,961.1 сая төгрөгөөр баталж, 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 5/01 дүгээр тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 142.4 сая төгрөгөөр буруулж 1,818.7 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,818.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,493.7 сая төгрөгийг урсгал зардалд, 217.6 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 107.4 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр татварын орлогоос 446.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс 931.7, үйл ажиллагааны орлогоос 21.5 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 200.8 сая, урьд оны үлдэгдлээс 218.7 сая, нийт 1,818.7 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,688.7 сая төгрөг буюу 91.9 хувийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 2.0 сая, ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 7.3 сая, Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 10.0 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 14.6 сая төгрөг, нийт 33.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 27.8 сая төгрөгийг зарцуулж 6.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.6.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Золоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 2-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2024 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,237.9 сая төгрөгийн 1.0 хувиар буюу 32.4 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 25.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2025 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,140.8 сая төгрөгийн 1.0 хувь буюу 31.4 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 25.1 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 169 мэдээллээс хугацаандаа оруулсан 159, хугацаа хоцроосон 10 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

Өлгий сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 57.4 сая төгрөгийг төсөвт өртөгтэй өвс, тэжээлийн нөөц бэлтгэх төсөл арга хэмжээг багийн гэж 3 хуваан төлөвлөн шууд худалдан авалт арга ашиглан гүйцэтгэгчийг шалгаруулан худалдан авалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”, 10.5 дахь заалтад “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүйд зөвлөмж өглөө.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 292.8 сая төгрөгийн 1 зөвлөмж өгснийг биелэлтийг 100% хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	268.3	1	268.3	100%
Нийт дүн	1	268.3	1	268.3	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөгөөр /

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шууд худалдан авалт хийсэн	1	57.4					1	57.4
Дүн	1	57.4					1	57.4
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  М.БАТЦУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР: М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР  Т.БОЛОО/

2026 оны 03 сарын 25-ны өдөр

